

**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 25/13

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөд их хэмжээний
хохирол учрах нөхцөл байдал үүссэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалт, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 138 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 7 дахь заалт, “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их хурал, Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн хорооны холбогдох шийдвэрүүдийн дагуу “Монгол шуудан” ХК-ийн 34 хувийг Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалж хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр “Ялган боловсруулах төв”-ийг барьж, ашиглалтад оруулан, хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд газар ашиглах эрхийг дуусгавар болгох замаар тус газар дээрх эд хөрөнгийг нөхөн төлбөргүйгээр буулгаж нураах мэдэгдэл ирүүлсэн нь хувьцаа эзэмшигчдийн эд хөрөнгө өмчлөх эрхэд халдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэх заалтыг зөрчиж, компанийн үйл ажиллагаанд их хэмжээний хохирол учрах нөхцөл байдлыг үүсгэж байгаа тул дараах арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай:

1.1. Зам, тээврийн яамны 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 03/3346 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдэгдэлд эрх бүхий байгууллагын албан ёсны шийдвэрийг дурдаагүй бөгөөд шийдвэр гаргахаас өмнө эрх ашиг нь хөндөгдөж буй этгээд буюу “Монгол шуудан” ХК-нд үнэн бодит мэдээллийг цаг тухайд нь ирүүлээгүй тул уг мэдэгдлийг хүлээн авах боломжгүй талаар хариуг энэхүү шийдвэрийн хамт албан бичгээр хүргүүлэх,

1.2. Зам, тээврийн яамны 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 03/3346 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдэгдэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Газрын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад холбогдох хууль, журмыг зөрчсөн илт үндэслэлгүй байх тул Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь хэсэгт заасны дагуу маргааныг хуульд заасан эрх бүхий субъект Засаг даргад хандан шийдвэрлүүлэх, газар

ашиглах эрхийн хугацаа сунгуулах хүсэлтийн хариу, тайлбарыг албан ёсоор бичгээр авах,

1.3. Зам, тээврийн яамны дээрх мэдэгдлээс шалтгаалан Дэлхийн 192 орны өмнө хүлээсэн Монгол Улсын Засгийн газрын үүрэг буюу шуудан солилцох үйл ажиллагаа тасалдах, компанийн өмч хөрөнгө үнэгүйдэх, хохирол учрах эрсдэлтэй тул үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх.

1.4. Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын /хуучнаар/ 2010 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тушаал, түүний хавсралтаар баталсан “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлын ерөнхий төлөвлөгөө”, Зам, тээврийн хөгжлийн яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Төв аймгийн Засаг даргын тамгын газар хооронд 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Улсын тусгай хэрэгцээний газрыг ашилах 155/2019/55 дугаар гэрээ, түүний хавсралт “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг газар ашиглалтын төлөвлөгөөний дагуу тус төлөвлөлтийн 25Б дугаарт төлөвлөгдөн Шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийн хүрээнд, нийтийн эрх ашгийн хүрээнд хэрэгжсэн бүтээн байгуулалтын ажил тул анхны төлөвлөлт болон “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг өргөтгөх шинэ төлөвлөлттэй холбоотой судалгаа, тооцоо, баримт мэдээллийг Зам, тээврийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газар болон холбогдох байгууллагаас шаардаж авах, үр дүнг танилцуулах.

2. Компанийн хөрөнгө, олох орлого, үйл ажиллагаа, хүний нөөц, цаг хугацаанд үүсэх хохирол, алдагдсан боломжийн зардлын тооцооллыг урьдчилсан байдлаар хийж танилцуулах, эрх бүхий хараат бус үнэлгээний хуулийн этгээдээр Хохирлын үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах асуудлыг судлан танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Д.Балдорж), Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн) нарт үүрэг болгосугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ДАРГА:

Д.НАРАНГЭРЭЛ /ТУЗ-ийн ердийн гишүүн/

ГИШҮҮД:

Д.ДЭЛГЭРМАА /ТУЗ-ийн ердийн гишүүн/

Д.БАЛЖИННЯМ /ТУЗ-ийн ердийн гишүүн/

Х.СҮРЭНХОРОЛ /ТУЗ-ийн ердийн гишүүн/

О.ОДБАЯР /ТУЗ-ийн ердийн гишүүн/

Г.УЯНГА /ТУЗ-ийн ердийн гишүүн/

Б.ГАНБААТАР /ТУЗ-ийн ХБ гишүүн/

Ч.АМАРБААТАР /ТУЗ-ийн ХБ гишүүн/

Д.БАЛДОРЖ /ТУЗ-ийн ХБ гишүүн/